



**БУЛГАН АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

63082 Булган, Булган аймаг

Утас: 7034-2938, Факс: 7034-2250

2021-10-20 № 06/1161

Танай _____-ны № _____ Т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Зөвлөмжийн хариу хүргүүлэх тухай

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн аудитын зөвлөмжийн хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдээдлийн 44 хувь буюу 1863,1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах ажлыг сумдын Засаг дарга нарт хариуцуулан биелэлтийг тооцож ажиллах

Булган аймгийн Засаг даргаар батлуулсан /2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 1/03 тоот/ удирдамжийн дагуу аймгийн ЗДТГ-ын ХЭЗХэлтэс, Санхүүгийн хяналт аудитын алба, ШШГА, Шүүхийн эвлэрүүлэн зуучлагч нарын хамтарсан баг 16 сумын сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан "Сум хөгжүүлэх сан"-ийн үйл ажиллагааг сайжруулах тухай аймгийн Засаг даргын албан даалгавар /2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот/-ыг сумдад хүргүүлэн хэрэгжилтийг тооцож ажиллаж байна. 2021 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 361,3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл төлөгдсөн байна.

2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, сургуулийн өмнөх байгууллагатай холбоотой авлагыг бүрэн барагдуулах

Хүүхдийн цэцэрлэгүүд 2021 онд 98,2 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын авлагыг барагдуулж 3-р улирлын байдлаар 70,3 сая төгрөгийн авлагатай байна. Хүүхдийн тоглоомын авлагыг 10 сард багтааж дуусгахыг төсвийн захирагч нарт үүрэг болгоод байна.

3. Төсвийн захирагч болон санхүүгийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, төсвийн зарцуулалт, санхүүгийн тайлагналд гарч буй зөрчлийн агуулгад дүн шинжилгээ хийж, бууруулахад анхаарч, өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг ханган ажиллах

Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудитаар илэрч буй нийтлэг алдаа зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулж ажиллах чиглэлээр төсвийн захирагч нарт 2021 онд 2 удаа албан тоот хүргүүлж, цахим уулзалтуудыг зохион байгуулж үүрэг даалгавар, зөвлөмж чиглэл өгч ажиллалаа. Цахим уулзалтад сумдын Засаг дарга, санхүүгийн албаны дарга, төсөвт байгууллагын нягтлан бодогч нар хамрагдсан.

4. Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1.2.1 дэх заалтыг мөрдөж ажиллах

20210079

Журмын заалтыг мөрдөн ажиллаж байна.

5. Аймгийн ТЕЗ-ийн зүгээс ОНӨГ-уудын үйл ажиллагаа, чадавхид үнэлэлт өгч, үр ашигт ажиллагааг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах

Монгол улсын Ерөнхий сайдын 2021 оны 46 дугаар захирамжаар төрийн болон орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг хэмнэлтийн горимд шилжүүлэн, шат дамжлага, чиг үүргийн давхардлыг арилгах замаар үйл ажиллагааны удирдлага, чиглэл, бүтэц орон тоог оновчтой болгох, зардлыг бууруулах асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулагдан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг албан бичгээр холбогдох сумдын Засаг дарга, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагуудад хүргүүлсэн. "Тэшиг-Ус" ОНӨААТҮГ, "Илчит Хутаг" ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлд Орон нутгийн өмчийн газрын төлөөлөл орж, дүрэм, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, үйл ажиллагааны зардлын төсвийг хэлэлцэн холбогдох шатны хурлаар батлуулаад байна. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 09, 46 дугаар тогтоолоор улсын хэмжээнд Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын ажил зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 06 сарын 02-ны өдрийн А/249 дүгээр захирамжаар үндсэн хөрөнгийн тооллогын ажил явуулах ажлын хэсэг байгуулагдаж "Тэшиг-Ус" ОНӨААТҮГ, "Илчит Хутаг" ОНӨААТҮГ-ын захиралтай байгуулсан гэрээ контракт, өр авлага, санхүүгийн тайлантай танилцаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцож, зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан болно.

Аймгийн Засаг дарга "Булган Мээж" ОНӨХХК, Дулааны станцын удирдлага, инженерүүд, холбогдох хэлтсийн дарга нартай уулзаж, үүсээд байгаа нөхцөл байдал, дулаан хангамж сайжрахгүй байгаа шалтгааныг тодруулж Дулааны станцыг төрийн мэдэлд авч, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиглэлээр аймгийн Засаг даргын албан бичгийг Монгол улсын Ерөнхий сайд, Эрчим хүчний сайд, Сангийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар зэрэг байгууллагад хүргүүллээ. Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрчим хүчний хөгжлийн төв зэрэг байгууллагын төлөөллийг багтаасан ажлын хэсэг Булган аймагт ажиллаж, үүсээд байгаа нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж аймгийн бодлого чиглэлийг дэмжин ажиллаж дулаан үйлдвэрлэх түгээх үйл ажиллагааг нэг компанид төвлөрүүлж ажиллах нь зүйтэй гэж үзэн, талуудын байр суурийг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар тогтоод байна.

6. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээ мэдээллийг хугацаанд нь цахим мэдээллийн санд байршуулж ажиллах

2021 оны 2 дугаар улирлын байдлаар аймгийн дүнгээр авч үзвэл нийт 234 байгууллага 13495 мэдээ оруулахаас 13318 мэдээллийг мэдээлж, шилэн дансны хуулийн хэрэгжилт 98,6 хувьтай байна. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах 106 мэдээллээс 98 мэдээллийг хугацаанд нь байршуулж 8 мэдээлэл хугацаа хоцорсон байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.БАТЦОГТ

